



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 27 өдөр

Дугаар А/135

Мөрөн сум


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.1, 4.1 Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын А/77 дугаар тушаал, Улсын Онцгой комиссын 2022 оны 02 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 04 сарын 21 ны өдрийн 12 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малын гоц халдварт шүлхий өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд улсын хэмжээнд бүх үхэр, гахай, сарлаг, цаа бугыг шүлхий өвчний дархлаажуулалтад хамруулах ажил зохион байгуулагдаж байгаатай холбогдуулан мал эмнэлгийн салбарын эмч, мэргэжилтнүүд сумдад ажиллахад шаардагдах зардалд 45,013,000 (Дөчин таван сая арван гурван мянган) төгрөгийг зарцуулсугай.
2. Мал эмнэлгийн газраас ирүүлсэн саналыг үндэслэн дээрхүйл ажиллагаанд шаардагдах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.
3. Дээрх зардлын 45,013,000 (Дөчин таван сая арван гурван мянган) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П. Ариунбат)-т зөвшөөрсүгэй.
4. Дархлаажуулалтад ажиллаж байгаа эмч, мэргэжилтнүүдийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, тайлан мэдээ, санхүүгийн баримтыг бүрдүүлэн холбогдох газарт хүргүүлж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Л.Ариунаа)-т үүрэг болгосугай.
5. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН



Аймгийн Засаг даргын 2022 оны 04
дугаар сарын 4-ны өдрийн
А/133 дугаар захирамжийн хавсралт

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ШҮЛХИЙ ӨВЧНИЙ ДАРХЛААЖУУЛАЛТ
ХИЙХ ЗАРДЛЫН ТӨЛӨВЛӨЛТ

№	Сумын нэр	Захирамжийн огноо	Захирамжийн дугаар	Малчи н өрхий н тоо	Хамрагдвал зохих малын тоо				Багт явах км	АЗД-ийн нөөцөөс гаргаж буй санхүүжи лт
					үхэр	цаа буга	гаха й	нийт		
1	Алаг-Эрдэнэ	4/15/2022	A/65	814	24600			24600	1920	1,496,500
2	Арбулаг	4/15/2022	A/41	1024	24400			24400	2990	1,485,000
3	Баянзүрх	4/15/2022	A/45	824	27300			27300	913	1,363,500
4	Бүрэнтогтох	4/15/2022	A/80	1040	26600			26600	3030	1,850,000
5	Галт	4/15/2022	A/30	779	19500			19500	4058	1,630,000
6	Жаргалант	4/15/2022	A/49	405	13300			13300	1000	1,590,000
7	Их Уул	4/15/2022	A/44	804	21644		56	21700	2880	1,430,000
8	Мөрөн	4/18/2022	A/61	903	20859		41	20900	2587	1,463,000
9	Рашаант	4/18/2022	A/41	647	13069		31	13100	1160	1,385,000
10	Рэнчинлхүмбэ	4/15/2022	A/49	1098	29400			29400	1270	1,910,000
11	Тариалан	4/14/2022	A/58	827	23740		360	24100	1810	1,650,000
12	Тосонцэнгэл	4/15/2022	A/37	877	21100			21100	4760	1,350,000
13	Төмөрбулаг	4/15/2022	A/61	265	21458			21458	2210	1,360,000
14	Түнэл	4/15/2022	A/71	976	30700			30700	3055	1,850,000
15	Улаан-Уул	4/15/2022	A/58	792	30793	7		30800	1550	1,799,500
16	Хатгал	4/15/2022	A/42	220	13376	24		13400	500	862,500
17	Ханх	4/18/2022	A/17	460	18000			18000	1800	1,020,000
18	Цагааннуур	4/18/2022	A/31	199	2883	2417		5300	800	850,000
19	Цагаан-Уул	4/21/2022	A/78	1334	31600			31600	3437	2,250,000
20	Цагаан-Үүр	4/18/2022	A/31	452	13200			13200	1400	950,000
21	Цэцэрлэг	4/16/2022	A/48	903	19000			19000	2450	1,750,000
22	Чандмань- Өндөр	4/13/2022	A/37	575	23300			23300	2144	1,252,000
23	Шинэ Идэр	4/15/2022	A/29	680	14100			14100	1100	1,320,000
24	Эрдэнэбулган	4/14/2022	A/26	612	20654		46	20700	1674	1,155,000
25	Сумдад ажиллах аймгийн ажлын хэсгийн томиллолт, шатахууны зардал	4/16/2022	A/117						8100	9,991,000
НИЙТ ДҮН				17510	504576	2448	534	507558	58598	45,013,000